



РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 8/10

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, "Радио телевизийн үндэсний сүлжээ" Улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.3.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын "Зөөврийн радио зангилаа, орчуулгын төхөөрөмжийг захиалгаар ажиллуулах журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаанд мөрдүүлэн ажиллахыг Хотын шугамын радиогийн алба (Э.Төмөрчөдөр), Захиргааны удирдлагын газар (Ц.Ганзориг) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын захирлын 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 75 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ



Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

1624010019

“Радио телевизийн үндэсний сүлжээ”
Улсын төсөвт үйлдвэрийн газрын
захирлын 2014 оны 21 дүгээр сарын
23-ны өдрийн тушаалын хавсралт

ЗӨӨВРИЙН РАДИО ЗАНГИЛАА, ОРЧУУЛГЫН ТӨХӨӨРӨМЖИЙГ ЗАХИАЛГААР АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын өөрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бусад байгууллагын захиалгаар синхрон орчуулгын төхөөрөмж, зөөврийн радио зангилаагаар үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Нэг. Захиалга хүлээн авах ажиллагаа

- 1.1. Зөөврийн радио зангилаа, орчуулгын төхөөрөмжийг ажиллуулахыг хүссэн албан бичгийг Захиргааны удирдлагын газар хүлээн авч, захиралд танилцуулан зөвшөөрөл авна. Албан бичигт хэдийд ямар хугацаатай ашиглах, хуралд оролцогчдын тоо, ашиглах сувгийн тоо, хаана суурилуулах зэргийг тодорхой дурдсан байна.
- 1.2. Захиргааны удирдлагын газар захиалагч байгууллагын хүсэлтийг захиралд танилцуулж, зөвшөөрөл олгосноор Хотын шугамын радиогийн албанд мэдэгдэнэ. Хотын шугамын радиогийн албаны дарга цаг хугацааг давхцуулалгүйгээр төхөөрөмжийг бэлтгэх, ажиллуулах, хяналт тавих ажлыг зохион байгуулна.

Хоёр. Захиалга гүйцэтгэх ажиллагаа

- 2.1. Уг төхөөрөмжийг хариуцсан инженер, техникийн ажилтнууд захиалгын дагуу төхөөрөмжийг бэлтгэж, хэвийн ажиллагааг шалгана.
- 2.2. Зөөврийн радио зангилаа, орчуулгын төхөөрөмжийг ашиглах өдрөөс 1 өдрийн (хамгийн багадаа 3 цаг) өмнө захиалгат заал, танхим, талбайд байгууллагын эсвэл захиалагчийн автомашинаар зөөвөрлөн суурилуулж, хэвийн ажиллагааг захиалагч талд шалгуулан төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал болон ажиллагааг захиалгын дагуу байгаа эсэхийг шалгуулна.
- 2.3. Зөөврийн радио зангилаа, орчуулгын төхөөрөмжийг инженер, техникийн ажилчид арга хэмжээ эхлэхээс нэг цагийн өмнө төхөөрөмжөө бүртгэн, хэвийн ажиллагааг шалгаж ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болгосон байна.
- 2.4. Төхөөрөмж ажиллуулах инженер, техникийн ажилчид хурлын хугацаанд хэвийн ажиллагааг хариуцан ажиллах, гэмтэл гарсан үед шаардлагатай арга хэмжээг хурдан шуурхай авах нөөц төхөөрөмжийг бэлдэх ажлыг шалгаж, хариуцан ажиллана.
- 2.5. Ажил дууссаны дараа инженер, техникийн ажилчид төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж хураан байгууллагын эсвэл захиалагчийн автомашинаар зөөвөрлөн ажлын байранд авчирна.
- 2.6. Төхөөрөмжийг авчирсны дараа техникийн үзлэг үйлчилгээ, шаардлагатай цэвэрлэгээг хариуцсан инженер хийж, дараагийн захиалгат ажлыг хийхэд техникийн бэлэн байдлыг хангасан байна.

- 2.7. Тухайн гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээллийг Хотын шугамын радиогийн албаны дарга Захиргааны удирдлагын газарт мэдээлнэ.
- 2.8. Захиалагч байгууллагын албан бичгийн хариуг албан бичгээр хүргүүлнэ.

Гурав.Төлбөр тооцоо

- 3.1. Захирлын тушаалаар батлагдсан зөөврийн радио зангилаа орчуулгын төхөөрөмж ажиллуулах үйлчилгээний тарифын дагуу орлогын нягтлан бодогч захиалагч байгууллагад төлбөрийг нэхэмжлэхээр нэхэмжилж байгууллагын дансанд хүлээн авна.

Дөрөв. Орчуулгын төхөөрөмжийг ажиллуулах инженер, техникийн ажилчдын эрх үүрэг

- 4.1. Захиалагчаас ирсэн тоног төхөөрөмжийн захиалгыг үндэслэн төхөөрөмжийг суурилуулах, хураах ажилд инженер, техникийн ажилчдыг доорх байдлаар оролцуулна. Үүнд:
- 4.1.1. 50 хүртэлх чихэвчтэй бол 3 хүртэл
- 4.1.2. 51-100 хүртэлх чихэвчтэй бол 4 хүртэл
- 4.1.3. 101-150 хүртэл чихэвчтэй бол 5 хүртэлх
- 4.1.4. 151-дээш чихэвчтэй бол 6 хүртэл инженер, техникийн ажилчид тус тус ажиллуулна.
- 4.2. Ажлын бус цагаар ажилласан инженер, техникийн ажилчдад ажилласан цагийг бүртгэж Захиргааны удирдлагын газарт батлагдсан маягтын дагуу нарядыг өгнө.
- 4.3. Ажлын бус цагаар зөөврийн зангилаа орчуулгын төхөөрөмж ажиллуулахад ажилласан инженер, техникийн ажилчдад тухайн ажлын гүйцэтгэлээс шалтгаалж нарядын дагуу ажлын хөлсийг урамшуулал болгон тооцож, үндсэн цалин дээр нэмж олгоно.
- 4.4. Инженер, техникийн ажилчид зөөврийн радио зангилаа орчуулгын төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.

Тав. Хариуцлага

- 5.1. Уг ажлыг хариуцан ажилласан инженер, техникийн ажилчид нь өөрийн буруугаас техникийн гологдол саатал гаргасан, захиалагч байгууллагаас гомдол гаргавал Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, журмын дагуу тухайн инженер, техникийн ажилчдад хариуцлага тооцно.
- 5.2. Инженер, техникийн ажилчид нь өөрийн буруугаас зөөврийн радио зангилаа орчуулгын төхөөрөмжид эвдрэл, гэмтэл учруулбал өөрийн зардлаар хохирлыг бүрэн барагдуулна.

Зургаа. Зөөврийн радио зангилаа болон орчуулгын төхөөрөмжийн үйлчилгээний тариф

№	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Тариф /төгрөгөөр/
Зөөврийн радио зангилаа			
1	100вт хүртэл чадалтай	Цаг	35 000
2	100-300вт хүртэл чадалтай	Цаг	70 000
3	300-600вт хүртэл чадалтай	Цаг	85 000

4	600-1500вт хүртэл чадалтай	Цаг	120 000
5	1500вт-аас дээш	Цаг	250 000
Орчуулгын төхөөрөмж			
1	Орчуулгын төхөөрөмж /үндсэн суваг/	Цаг	45 000
2	Орчуулгын төхөөрөмж /2-4 суваг/	Үндсэн суваг+суваг/цаг/	35 000
3	Чихэвчийн үнэ	Цаг/тоо ширхэг	1 000
4	Техникийн ажлын хөлс	50 хүртэл чихэвчтэй	50 000
		51-100 хүртэл чихэвчтэй	75 000
		101-150 хүртэл чихэвчтэй	100 000
		151-200 хүртэл чихэвчтэй	125 000
		201-250 хүртэл чихэвчтэй	150 000
		251-300 хүртэл чихэвчтэй	175 000
		301-350 хүртэл чихэвчтэй	200 000
		351-400 хүртэл чихэвчтэй	225 000
		401-450 хүртэл чихэвчтэй	250 000
		451-500 хүртэл чихэвчтэй	275 000
		501-ээс дээш чихэвчтэй	300 000
5	10-20 микрофон ажиллуулах	Цаг	50 000
Шугамын радио			
1	Радио шугамын суурь	Сар	330

Жич: 30 километрээс дээш зайд зөөврийн радио зангилаа орчуулгын төхөөрөмж захиалгаар ажиллуулах тохиолдолд төхөөрөмж тээвэрлэх тээврийн зардал, инженер техникийн ажилтнуудын байр, хоолны зардлыг захиалагч байгууллага хариуцна.

Долоо. Урамшуулал олгох заавар

7.1. Зөөврийн радио зангилаа орчуулгын төхөөрөмжийг ажиллуулсан төлбөрийг байгууллагын дансаар хүлээн авах ба байгууллага төлбөрийн 70 хувийг авч, 30 хувийг төхөөрөмжийг суурилуулах буцааж хураах ажилд оролцсон инженер, техникийн ажилчдад дараах байдлаар ажлын хөлсийг тооцож олгоно. Үүнд:

№	Чихэвчний тоо	Ажиллах хүч (олгогдох хөлс)	
		Инженер	Техникийн ажилтан
1	50 хүртэл чихэвчтэй	1 хүн (15%)	2 хүн (тус бүр 7,5%)
2	51-100 хүртэл чихэвчтэй	1 хүн (12%)	3 хүн (тус бүр 6%)
3	101-150 хүртэл чихэвчтэй	2 хүн (тус бүр 7,5%)	3 хүн (тус бүр 5%)
4	151-ээс дээш чихэвчтэй	2 хүн (тус бүр 6%)	4 хүн (тус бүр 4,5%)